



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 7 сарын 10 -ны өдөр

Дугаар А/73

Эрэлт

Г Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх тусламж
үйлчилгээг эрчимжүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 31 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын "Түр заавар батлах тухай" 2021 оны А/254 дүгээр тушаал, 2021 оны А/456 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жирэмсэн, төрсний дараах эх, өндөр настан, архаг суурь эмгэгтэй эрсдэлт бүлгийн иргэдэд коронавируст халдвар /КОВИД-19/-ын шинж тэмдгийг эрт илрүүлэх, тандах, эмнэлгийн тусламж үйлчилгээг эрчимжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, зорилтот болон эрсдэлт бүлгийн иргэдийг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулах журмыг хоёрдугаар, эрсдэлт бүлгийн иргэдэд тандалт судалгаа хийсэн, гэрийн тусгаарлалт, хяналтад авсан, тусгаарлах эмнэлэгт шилжүүлсэн бүртгэл мэдээллийн загварыг гуравдугаар хэвсрэлтээр тус тус баталсугай.
2. Эрсдэлт бүлгийн иргэдийг шинж тэмдгийн тандалт, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг тасралтгүй төлөвлөн зохион байгуулж тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.
3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын гэрийн тусгаарлалт хяналт, эрсдэлт бүлгийн иргэдийн тандалт илрүүлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллийг нэгтгэн хариу арга хэмжээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Т.Нарантуяа /УАУХМ/, П.Хишгээ /ЭХТҮХМ/, Г.Итгэл /ЭМСМХМ/ нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Б.Уртнасан /ЭТҮХМ/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

**ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДЭД КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫГ ЭРТ
ИЛРҮҮЛЭХ, ТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАН ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ
ЭРЧИМЖҮҮДЭХ ТАЛАВЛАГАА**

№	Ажил ажиллууд	Ажлын өдөр	Хариуцаж байгаа сум, сум дундын дарга, бүртгэл мэдээллийн ажилтан	ЭМГ-ын эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
1	Жирэмсэн эх, 55 наснаас дээш өндөр настан, архаг суурь хавсарсан өвчтэй өндөр эрсдэлтэй бүлгийн иргэдийн тоон судалгааг гаргаж, нэгтгэх	2021.07.08	Сум, ӨЗМТөвийн дарга, бүртгэл мэдээллийн ажилтан	ЭМГ-ын эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Г.Итгэл
2	Судалгааны дагуу эрсдэлтэй бүлгийн иргэд, жирэмсэн эх, төрсөн эхэд шинж тэмдэгийн тандалтыг өдөр бүр хийж, ЭМГ-т загварын дагуу мэдээлэх, нэгтгэн дүгнэх	2021 оны 7 сарын 08-наас эхлэн өдөр бүр	Сум, ӨЗМТөвийн дарга, бүртгэл мэдээллийн ажилтан	ЭМГ-ын эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Г.Итгэл
3	Зорилтот болон эрсдэлт бүлгийн иргэдийг хуваарийн дагуу шинжилгээнд хамруулах	<ul style="list-style-type: none"> Жирэмсний 28 - 40 долоо хоногтой эх 	2021 оны 7 сарын 13,14,15,	Сум, ӨЗМТөвийн дарга, бүртгэл мэдээллийн ажилтан ЭМГ Б.Батцэцэг А.Баярхүү
		<ul style="list-style-type: none"> Жирэмсний 4-28 долоо хоногтой эх Төрсний дараахь 42 хоног доторх эхчүүд 	2021 оны 7 сарын 15,16,17,18,19,	Сум, ӨЗМТөвийн дарга, бүртгэл мэдээллийн ажилтан ЭМГ Б.Батцэцэг А.Баярхүү
		<ul style="list-style-type: none"> Суурь өвчтэй, хавдартай, АД ихсэлт, сахар, таргалалт 4.5-р бүлгийн иргэд 55-аас дээш насны ахмад настан 	14 хоног тутамд 1 удаа шинж тэмдгийн болон ПГУ, тест шинжилгээнд хамруулах	Сум, ӨЗМТөвийн дарга, бүртгэл мэдээллийн ажилтан ЭМГ Б.Батцэцэг А.Баярхүү
4	Эмнэлзүйн шинж тэмдэгтэй, PCR болон антиген тестээр эерэг гарсан эрсдэлт бүлгийн иргэдийг гэрийн эмчилгээ хяналтад авсан, тусгаарлах эмнэлэгт хэвтүүлэхээр илгээсэн тухай мэдээллийг ЭМГ-т шуурхай ирүүлж эргэх холбоотой ажиллах	Өдөр бүр	Сум, ӨЗМТөвийн дарга, эмч нар	Тусгаарлах эмнэлгүүд -БОЭТ -Ачит -МСҮТ -Баян-Өндөр -Медипас
5	Шинж тэмдэг илэрсэн болон PCR болон антиген тестээр эерэг гарсан жирэмсэн эх, төрсний дараахь 42 хоног доторхи эхчүүдийг БОЭТөвд шуурхай шилжүүлэн хэвтүүлэх	Тухай бүр	Сум, ӨЗМТөвийн дарга, эмч нар	БОЭТ СӨЗМТ-үүд

6	Гэрийн эмчилгээ хяналтанд үлдээж байгаа батлагдсан тохиолдлын гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийн иж бүрэн үзлэгт хамруулж хүндрэх эрсдэлтэй, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулах, онцгой анхаарах	Өдөр бүр	Сум, ӨЗМТөвийн дарга, эмч нар	ЭМГ Н.Чулуун-Эрдэнэ Д.Отгондалгэр Алтанзагас
7	Эрсдэлт бүлгийн иргэдэд үзүүлж байгаа коронавируст халдвар /КОВИД-19/-ын тусламж үйлчилгээнд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх	7 хоног тутам	ЭМГ Т.Нарантуяа П.Хишгээ Г.Итгэл	Сум, ӨЗМТөвүүд
8	Эрсдэлт бүлгийн иргэдийг тогтмол хяналтад байлгахад төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх	7хоног тутам	Сум, ӨЗМТөвийн дарга, эмч нар	ЭМГ
9	Эрсдэлт бүлгийн иргэдэд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмж, нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх	7хоног тутам	Сум, ӨЗМТөвийн дарга, эмч нар	ЭМГ.

**Эмчилгээний багцын зарцуулалт, хүргэлтэд хяналт тавих
албан хаагчдын хуваарь**

№	Байгууллагуудын нэрс	Хяналт тавих мэргэжилтнүүд		
		Нярав Алтанзагас	Нягтлан Н.Чулуунэрдэнэ	Эдийн засагч Д.Отгондэлгэр
1	Анхны оч			
2	Энхжихмандирваа			
3	Мөнхсундрэл			
4	Нийцэл			
5	Үйлсбадрах			
6	Учралтбаяр			
7	Мэндцэцэн			
8	Мөнхийн гэгээ			
9	Жаргалант сумын эрүүл мэндийн төв			

Эмчилгээний багцын зарцуулалтын тайлангийн загвар

1. Нийт эмийн багц өгсөн айл өрхийн тоо – , гэр бүлийн гишүүдийн тоо –
2. Багцад хамрагдсан шалтгаан: Амьдралын баталгаат түвшнээс доогуур орлоготой, эрүүл мэндийн даатгалгүй, эрсдэлт бүлгийн гэх мэтчилэн
3. Багц авсан өрхийн өвчилж эдгэрсэн хугацаа
4. Тухайн өрхөөс эмийн багцад хамрагдсан боловч шинжилгээгээр батлагдаж эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, шалтгаан

